

ГАЛ ТҮЙМЭР УНТРААХ ХҮЧ ХЭРЭГСЛИЙГ БАЙРЛУУЛАХ

С.Баттөмөр

*ДХИС-ийн ОБС-ийн Гал түймэртэй тэмцэх албаны тэнхимийн эрхлэгч,
хурандаа*

Цахим шуудан: battumur777@yahoo.com

Хураангуй

Хүч хэрэгслийг байрлуулах болон дараа дараагийн үйл ажиллагааны явцад гал түймэр унтраах үйл явцад оролцогчдын аюулгүй байдлыг хангах, ирсэн галын автомашин техникийн шилжин байрлах боломжийг нэмэгдүүлэх, нөөц галын техникийг суурилуулах боломжийг хангахын тулд гал түймэр гарсан газарт гадны хүмүүсийг орохыг хязгаарлах, хориглох мөн тухайн нутаг дэвсгэрт тээврийн хэрэгсэлийн хөдөлгөөнийг хязгаарлах шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлж болно. Дотоод хэргийн байгууллагуудын зохих албад ирэхээс өмнө энэхүү ажиллагааг гал түймэр унтраах удирдагчийн шийдвэрийн дагуу бие бүрэлдэхүүн гүйцэтгэж болно.

Түлхүүр үгс: Хүч хэрэгсэл, бэлэн байдал, усан хангамж, удирдагч, хариу арга хэмжээ, сургалт, бэлтгэл, аюулгүй ажиллагаа, мэдлэг, чадвар, дадал, бие бялдар, ур чадвар, сэтгэлзүй, багийн ажиллагаа, урьдчилан сэргийлэх.

Хүч хэрэгслийг байрлуулна гэдэг нь гал түймэр унтраах аврах ажиллагаа явуулахаар дуудлагын газарт бэлэн байдалтай хүрэлцэн ирсэн хүч хэрэгслийг байрлуулах бие бүрэлдэхүүний ажиллагаа юм. Хүч хэрэгслийг байрлуулах үйл ажиллагаа нь дараах үндсэн үе шатуудыг багтаадаг:

- Хүч хэрэгслийг байрлуулахад бэлтгэх;
- Хүч хэрэгслийг урьдчилан байрлуулах;
- Хүч хэрэгслийг бүрэн байрлуулж дуусгах;

Бие бүрэлдэхүүн гал түймрийн дуудлагын газарт ирсний дараа шууд хүч хэрэгслийг байрлуулахад бэлтгэнэ. Энэ тохиолдолд:

- Гал унтраах автоцистернийг усны эх үүсвэрт холбож, галын насосыг ажлын байдалд шилжүүлнэ;
- Шаардлагатай тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг бэхлэнэ;
- Гал түймэр унтраах удирдагч өөр үүрэг тавиагүй бол хошуу бүхий хоолойн ажлын шугамыг насосны даралтад хоолойд холбоно;

- Бусад бэлтгэл ажиллагааг гал түймэр унтраах удирдагчийн шийдвэрийн дагуу гүйцэтгэнэ;

Гал түймэр унтраах удирдагч үүрэг өгч гал түймэр унтраах ажлын цаашдын зохион байгуулалт тодорхой болсон тохиолдолд гал түймрийн дуудлагын газарт хүч хэрэгслийг урьдчилан байрлуулна.

Урьдчилан байрлуулах явцдаа:

- Бие бүрэлдэхүүнийг байрлуулах бэлтгэл ажлын үед урьдчилан тусгагдсан ажиллагааг биелүүлнэ;
- Гал унтраах даралтын хоолойн шугамыг дэлгэнэ;
- Ажлын шугамыг дэлгэх галын хоолой болон хошууг байрлуулах хэсэг бусад шаардлагатай галын техник багаж хэрэгсэл тоног төхөөрөмжийг суурилуулна;

Гал түймэр унтраах удирдагчийн шийдвэрээр гал унтраах бодис өгөх зайлшгүй шаардлагатай тохиолдолд гал түймэр гарсан газарт хүч хэрэгслийг бүрэн байрлуулна.

Хүч хэрэгслийг бүрэн байрлуулахдаа:

- Хүч хэрэгслийг урьдчилан байрлуулах үед тодорхойлсон үйл ажиллагааг биелүүлнэ;
- Ажлын хоолойн шугамыг дэлгэж буй хошуучин гал сөнөөгчдийн байрлалыг тодорхойлно;
- Төв шугам болон ажлын хоолойн шугамыг гал унтраах бодисоор дүүргэнэ;

Хүч хэрэгслийг байрлуулах болон дараа дараагийн үйл ажиллагааны явцад гал түймэр унтраах ажиллагаанд оролцогчдын аюулгүй байдлыг хангах, ирсэн галын автомашин техникийн шилжин байрлах боломжийг нэмэгдүүлэх, нөөц галын техникийг суурилуулах боломжийг хангахын тулд гал түймэр гарсан газарт гадны хүмүүсийг орохыг хориглох мөн тухайн нутаг дэвсгэрт тээврийн хэрэгсэлийн хөдөлгөөнийг хязгаарлах шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлж болно. Тусгай чиг үүрэг бүхий байгууллагуудын зохих албад ирэхээс өмнө энэхүү ажиллагааг гал түймэр унтраах удирдагчийн шийдвэрийн дагуу бие бүрэлдэхүүн гүйцэтгэж болно.

Галын хоолойг дэлгэх үедээ:

- Хошуучин гал сөнөөгчдийн байрлалд хүрэх хамгийн богино замыг хүмүүс болон өмч хөрөнгийг аврах замд саад болохгүй байдлаар сонгоно;

- Галын хоолойн гүүр суурилуулах, хоолойн холбоос ашиглах үедээ тэднийг гэмтэх цоорохоос хамгаалах шаардлагатай;
- Замын зорчих хэсгээс гадна салаа бэлчирийг байрлуулна;
- Үйл ажиллагааны шийдвэрлэх чиглэлд галын нөөц хоолой байрлуулах;
- Галын хоолойн машин ашиглан хоолойн шугамыг дэлгэхдээ түүний ашиглалтын зааврын дагуу гүйцэтгэх ёстой;

Гал түймэр унтраах удирдагч нь цагийн байдлыг үнэлсний дараагаар гал түймэр унтраах ажиллагааг эхлүүлэх шийдвэрийг гаргана. Энэхүү шийдвэрийг тушаал байдлаар төлөвлөнө.

Гал түймэр унтраах ажиллагааны тушаалд:

- Гал түймэр унтраах үндсэн болон тусгай зориулалтын автоцистернийг байрлуулах газар;
- Хүч хэрэгслийг байрлуулах төрөл, онцлог;
- Ажиллагаанд оруулах хошууны тоо, төрөл;
- Гал түймэр унтраах аврах анги, тасгийн гүйцэтгэх чиг үүрэг зэргийг зааж өгнө;


Шаталтыг зогсоох

Шаталтыг зогсооно гэдэг нь гал түймэр гарсан газарт бодис, материалын шаталтыг зогсоох, мөн гал түймрийн голомтод гал унтраах бодис өгөх замаар шаталтыг хязгаарлах нөхцөлийг хангасан бие бүрэлдэхүүний ажиллагааг хэлнэ. Гал унтраах бодисыг сонгохдоо шатаж буй зүйлийн физик-химийн шинж, өгөгдсөн үүрэг, шаталтыг зогсоохоор хэрэглэж буй арга, бусад нөхцөл байдлаар сонгодог.


Үндсэн үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай өгөгдөж буй гал унтраах бодисын тоо хэмжээ, зарцуулалт нь галын тархалт, түүнийг унтраах ажлын зохион байгуулалтын онцлог, гал түймэр унтраах аврах анги, тасгийн тактикийн боломж, ашиглаж буй галын техник, тусгай тоног төхөөрөмжийн техникийн үзүүлэлтийн тогтоосон хугацаа, журам, зөвлөмжөөр тогтоосон тэдгээрийн өгөлтийн шаардагдах эрчийг харгалзан, гал түймэр унтраах бодит нөхцөл байдал туршлагыг үндэслэн тодорхойлдог.

Шийдвэрлэх чиглэл гэдэг нь тухайн цаг хугацаанд үндсэн үүргээ хэрэгжүүлэх хамгийн сайн нөхцөлийг хангасан тусгай зориулалтын техник, тоног төхөөрөмж, багаж зэвсэглэмж, хүч хэрэгслийг ашиглаж буй гал түймэр унтраах аврах анги, тасгийн үйл ажиллагааны чиглэл юм.


Шийдвэрлэх чиглэлийг тодорхойлох зарчим:




1. Хүний амь насанд бодит аюул учруулахаар гал түймрийн нөхцөл байдалд нэрвэгдэгсэд болон оролцогчид, аврагчид бие даан өөрсдийгөө гаргах боломжгүй тохиолдолд хүч хэрэгслийг хүмүүсийг аврах ажиллагаанд чиглэнэ.




2. Гал түймэр унтраах аврах ангийн хүч хэрэгсэл нь барилгын хийц бүтээцүүдийг дэлбэрэх болон нурулт үүсэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг хангах, аюулгүй бүсийг бий болгох.



3. Гал түймэр тухайн барилга байгууламжийг бүрэн хамарсан болон түүний тархалт нь хөрш зэргэлдээ барилгуудад аюул үүсгэхээр нөхцөлд унтраах хүч хэрэгслийг хамгийн их хохирол учруулах бүс рүү чиглүүлнэ.



4. Тухайн барилга байгууламж тусдаа гал түймэрт өртсөн бөгөөд хөрш зэргэлдээ барилгуудад түүний тархалт аюул учруулахааргүй нөхцөлд гал түймэр унтраах бүрэлдэхүүн нь уг газарт хүч хэрэгслийг байрлуулан ажиллана.



5. Гал түймэр унтраах бүрэлдэхүүнийг хүрэлцэн ирэхээс өмнө уг барилга байгууламж нь галд бүрэн өртсөн бол түүний тархалт шилжихээс хамгаалан, хөрш зэргэлдээ барилгыг хамгаалах ажиллагаанд хүч хэрэгслийг чиглүүлэн ажиллана.

Гал түймэр гарсан газарт хүч хэрэгслийг ашиглах зарчим:

Юуны өмнө хүч хэрэгслийг шийдвэрлэх чиглэлд ашиглана. Шийдвэрлэх чиглэлд үндсэн хүч хэрэгслээ төвлөрүүлсний дараа бусад чиглэлд гал түймэр унтраах хүч хэрэгслийг ажиллагаанд оруулна. Гал түймэрийн хэмжээ анхны дуудлагаар ирсэн анги, тасаг түүнийг унтраахад хангалтгүй болсон тохиолдолд нэмэлт дуудлага өгөх шаардлагатай ба энэ үед байгаа хүч хэрэгслээрээ тусламж ирэх хүртэл гал түймрийн тархалтыг барьж, нэмэлт хүч ирсний дараа хамтран гал түймрийг бүрмөсөн унтраана. Гал түймэр унтраах ажиллагааны цагийн байдал хүндэрсэн, хот, суурин газрын хүч хэрэгслээр унтраах боломжгүй хэмжээнд хүрсэн бол аж ахуйн нэгж, байгууллагын ажилчид, иргэд, цэргийн ангиудыг татан оролцуулж,

барилгын хийцийг ангилах, гал түймрийн аюулаас хамгаалах орон зай бий болгох зорилгоор шатамхай бодис материалыг цэвэрлэх, зөөвөрлөх ажлыг зохион байгуулна.

Галын гар хошуутай ажиллахдаа:

- Гал унтраах бодисын анхны өгөлтийг шийдвэрлэх чиглэлд өгөх;
- Гал унтраах бодисыг аюулгүйн техникийн горимыг мөрдөн шууд гал түймрийн голомтод өгөх;
- Гал түймрийн тархалтыг хязгаарлах, барилгын хийцэд нуралт үүсэхээс сэргийлэн хийцийн материал, тоног төхөөрөмжийг хөргөх;
- Гал унтраах бодисын өгөлтийг тасалдуулахгүй байх, гал түймэр унтраах удирдагчийн зөвшөөрөлгүйгээр байрлалыг орхихгүй байх;
- Шаталтыг зогсоохын тулд ашиглаж буй хөөс болон нунтагийн давхаргад ус нөлөөлөх тохиолдол гаргахгүй байх;
- Усыг үр ашиггүйгээр зарцуулахгүй байх шаардлагатай;

Гал унтраах бодис өгөх зайлшгүй шаардлагыг бий болгохын тулд байгаа инженерийн байгууламж, барилга байгууламжийн холбоо харилцааг ашиглаж болох ба барилгын хийцийг задлах, ангилах тусгай ажил гүйцэтгэж болно. 0,38 кВ ба түүнээс дээш хүчдэлтэй цахилгаан төхөөрөмж оршин байгаа газарт цахилгаан дамжуулдаг гал унтраах бодис өгөхдөө тухайн суурин газрын болон байгууллагын эрчим хүчний албаны тодорхой эрх мэдэл бүхий албан тушаалтнаас зохих журмын дагуу зөвшөөрөл авч ажилтнаар төхөөрөмжийг салгуулсны дараа гал унтраах бодисыг өгнө.

Тусгай ажил үүрэг гүйцэтгэх

Тусгай ажил үүрэг гэдэг нь тусгай техник хэрэгсэл болон тусгай мэдлэг, чадвар ашиглан үүрэг гүйцэтгэхэд чиглэсэн бие бүрэлдэхүүний ажиллагааг хэлнэ. Тусгай ажил үүрэг гүйцэтгэхэд:

- Гал түймэр унтраах холбоо зохион байгуулалтыг хэрэгжүүлэх;
- Дуудлагын болон гал түймэр гарсан газрыг гэрэлтүүлэх;
- Барилгын хийцийг задлан ангилах;
- Өндөрт гарах;
- Хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх;
- Нэрвэгдэгсдэд эмч ирэхээс өмнө анхны тусламж үзүүлэх;
- Техник хэрэгслийн эвдрэл гэмтэлгүй бүрэн ажиллагаатай байдлыг сэргээх зэрэг хамаарна;

Гал түймэр унтраах хүч, хэрэгслийг удирдлагаар хангах мөн гал түймэр гарсан буюу дуулагын газарт хамтын ажиллагаа, уялдаа холбоог хангахын тулд холбоо харилцааг зохион байгуулна. Холбоо харилцааг зохион байгуулах ажил нь гал түймэр унтраах удирдагчийн ашиглах холбооны сүлжээг тодорхойлох, холбооны хэрэгслийг ашиглахад бэлтгэх, үүрэг гүйцэтгэж буй бие бүрэлдэхүүнд үүрэг тавих зэргийг багтаана. Холбоо ашиглахдаа мэдээлэл дамжуулах тогтсон журам, мөн түүнчлэн радио холбооны журмыг мөрдөх ёстой. Гал түймэр унтраах удирдагчийн заавраар үзэгдэх орчин хязгаарлагдмал газарт мөн түүнчлэн утаа ихтэй үед гал түймэр гарсан газрыг гэрэлтүүлнэ.

Гал түймэр гарсан газрыг гэрэлтүүлэхийн тулд зэвсэглэлд буй тусгай зориулалтын автоцистерний гэрэлтүүлэх төхөөрөмж, мөн түүнчлэн энэ зорилгоор ашиглагдах бусад хэрэгслийг ашиглана. Дуудлагын газарт гал түймэр унтраах удирдагчийн шийдвэрээр тухайн байгууллагын гэрэлтүүлгийн хэрэгслийг нэмэлтээр ашиглаж болно. Хүмүүс болон өмч хөрөнгийг авран хамгаалах, гал түймрийн тархалтыг хязгаарлах, шаталтын бүсэд гал унтраах бодис өгөх бусад ажлыг гүйцэтгэх зорилгоор барилгын хийцийг задлах ангилах ажлыг гүйцэтгэдэг. Тухайн гал түймрийн голомтыг унтраахад зайлшгүй шаардлагатай хүч хэрэгслийг төвлөрүүлсний дараагаар шаталтын нуугдмал голомтод хүрч очихын тулд барилгын хийцийг задлах, нураах ажил хийгдэнэ.

Хүмүүс болон эд хөрөнгийг авран хамгаалах, шаардлагатай хүч хэрэгслийг төвлөрүүлэх, гал унтраах бодис өгөх, бусад ажлыг гүйцэтгэх зорилгоор өндөрт авирч гарах ба барилгаас гарах зам, аврах хэрэгсэл, бусад аврах ажиллагаанд зориулсан техник хэрэгслийг ашиглан ажлыг гүйцэтгэнэ. Шаардлагатай тохиолдолд энэ зорилгоор бусад тусгай зориулалтын хэрэгслүүдийг ашиглаж болно. Бие бүрэлдэхүүнийг өндөрт гаргахад ашиглагдсан аврах техник хэрэгслийг ажиллагаа явуулж буй бие бүрэлдэхүүнд мэдээлэл хүргэсний дараа байрнаас нь хөдөлгөнө.

Гал түймэр унтраах болон анхан шатны аврах ажиллагаа явуулах, өгөгдсөн үүргийг амжилттай биелүүлэх аюулгүй нөхцөлийг хангах зорилгоор хамгаалах арга хэмжээ авна. Хамгаалах арга хэмжээг тогтоосон журмын дагуу хэрэгжүүлэхдээ тоног төхөөрөмж, механизм, технологийн төхөөрөмжүүд, агааржуулалтын төхөөрөмж, цахилгаан тоног төхөөрөмж, халаалтын систем, газын хангалт, объектын тээврийн хэрэгслийн дотор болон гадна талд буй өндөр эрсдэлийн эх сурвалжуудыг унтрааж, салгаж, залгах, хаалт тавьж, шаардлагатай тохиолдолд эвдэж болно.

Хүчдэлд холбоотой цахилгаан тоног төхөөрөмжийг объектын болон суурин газрын эрчим хүчний албаны мэргэжилтнүүд эс бөгөөс гал

түймэр унтраах удирдагчийн шийдвэрээр салгаж болно. Шаардлагатай тохиолдолд 0,22 кВ хүртэл хүчдэл бүхий цахилгаан дамжуулагч утас, бусад тог бүхий элементүүдийг тэдгээр нь хэрвээ гал түймэр унтраах ажиллагаанд оролцогчдод аюул учруулж, гал түймрийн шинэ голомт үүсгэх аюулыг бий болгож ажиллагаа явуулахад саад учруулж байвал гал түймэр унтраах удирдагчийн шийдвэрээр бие бүрэлдэхүүн салгаж болно.

Энэхүү тохиолдолд резин гутал, битүү хамгаалалтын хувцас, тусгай хайч хэрэглэнэ. Гал түймэр унтраах хэм хэмжээ бүхий бичиг баримтуудад тогтоосон журмын дагуу бие бүрэлдэхүүн гал түймэрт нэрвэгдэгсдэд эмч ирэхээс өмнө эмнэлгийн анхны тусламж үзүүлнэ. Энэ тохиолдолд амьсгалын эрхтнийг хамгаалах хүн нэг бүрийн хэрэгсэл АБДТ, эмнэлгийн анхны тусламжийн хэрэгсэл, бусад тусгай хэрэгслүүдийг ашиглаж болно. Техник хэрэгслийн эвдрэл гэмтэлгүй бүрэн ажиллагаатай байдлыг сэргээх гэдэг нь гал түймэр гарсан газарт галын техник, багаж хэрэгсэл, тоног төхөөрмж, удирдлагын болон холбоо харилцааны хэрэгсэлийг гал түймэр унтраах үүргийг шийдвэрлэх зорилгоор ашиглах шаардлагатай үед түр засвар, техникийн үйлчилгээнд оруулах хойшлуулшгүй ажлыг хэлнэ.

Гал түймэр унтраах аврах ангийн байрлалд буцаж ирэх

Гал түймэр унтраах аврах анги, тасгийн байрлалд эргэж ирнэ гэдэг нь гал түймэр унтраах техник, хүч хэрэгсэл гал түймэр гарсан газраас байнгын байршилд эргэж ирэх бие бүрэлдэхүүний ажиллагаа юм. Энэ үед гал түймэр гарсан газарт үзлэг хийн, гал авалцах боломжит голомт үгүй болохыг тогтоох ёстой. Ангийн байрлалд эргэж ирэхийн өмнө дараах ажлуудыг хийж гүйцэтгэнэ:

- Бие бүрэлдэхүүнийг шалгана;
- Бүртгэлийн дагуу тоног төхөөрөмж, галын техник, хэрэгслүүдийн бүрэн эсэхийг шалгана;
- Гал түймэр унтраах үндсэн албаны автомашинд тоног төхөөрөмж, багаж хэрэгслүүдийг байрлуулж бэхэлнэ;
- Ашиглаж байсан усан хангамж, объектын гал унтраах гадна, дотор усан хангамж, системийн аюулгүй байдалд оруулах арга хэмжээ авна;
- Шаардлагатай тохиолдолд гал түймэр унтраахад ашигласан гал унтраах бодисыг цэвэрлэнэ;

Гал түймэр гарсан газарт хүч хэрэгсэл цугларч дууссан ангийн байрлалд буцахад бэлэн болсон тухай тасгийн дарга, гал түймэр унтраах удирдагч болон шуурхай удирдлагын төвийн зохицуулагчид илтгэнэ.

Байнгын байрлалд буцаж ирэхдээ хамгийн дөт замаар ангийн дуудлага хүлээн авагчтай холбоо барьж ирнэ. Энэ үед үндсэн албаны автомашинуудыг усаар цэнэглэх ажлыг хийж гүйцэтгэх ёстой.

Дүгнэлт:

Гал түймэр гарсан газарт хүч хэрэгслийг тараан байрлуулах, хүмүүсийг аврах ажиллагаа нь гал түймэр унтраах хүч хэрэгслийг байрлуулах арга хэмжээтэй зэрэг явагддаг. Энэ тохиолдолд гал түймэр унтраах аврах анги, тасгийн үйл ажиллагааны олон хувилбарыг ашиглах боломжтой. Гал түймэр гарсан газарт хангалттай хүч хэрэгсэл ирсэн тохиолдолд гал түймэр унтраах удирдагч өөрийн биеэр аврах ажиллагааг удирдан, хүмүүсийг гал түймрээс аврах ажиллагааг зохион байгуулах үүрэгтэй, үүний зэрэгцээ түүний удирдлагаар гал түймэр унтраах хүч хэрэгслийг байрлуулах үйл ажиллагаа явагдана. Хүмүүст галын аюул бодитой учирч тэднийг аврах зам, гарц галаар тусгаарлагдсан тохиолдолд хүмүүсийг аврахын тулд заавал галын хошууг ажиллуулж эхэлнэ. Гал түймэр гарсан газарт хангалттай хүч хэрэгсэл ирсэн ч хүмүүсийн амь насанд аюул учраагүй тохиолдолд эсвэл гал түймэр унтраах удирдагч тухайн гал түймрийн замд угтан оруулсан хүч хэрэгслээр унтраах боломжтой гэж үзсэн тохиолдолд анги, тасгийн үйл ажиллагааг хүмүүсийг цочирдолд орох эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд чиглүүлнэ. Хэрвээ гал түймэр унтраах, хүмүүсийг аврах ажиллагаа явуулахад хүрэлцэн ирсэн хүч хэрэгсэл хангалтгүй тохиолдолд гал түймэр унтраах аврах анги, тасгийн бие бүрэлдэхүүн аврах ажиллагаа явуулсны дараагаар гал түймрийг унтраах ажиллагаанд оруулна. Энэ тохиолдолд гал хүмүүст шууд аюул занал учруулах болон тэднийг аврах зам, гарцад гал түймэр тархах боломжтой тохиолдолд гал унтраах хошууг өгнө. Гал түймрээс хүмүүсийг аврах, нүүлгэн шилжүүлэхийн тулд хамгийн богино аюулгүй замыг ашиглана.

Ашигласан материал:

1. Гал түймэр унтраах дүрэм УБ., 2016.
2. Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн дүрэм УБ., 2018
3. Т.Лхамжав., Гал унтраах арга зүй, УБ 2009.
4. Т.Лхамжав., Гал унтраах удирдагчийн сэтгэл зүй, УБ 2001.
5. О.Ганхуяг., Гал унтраах мэргэжлийн сургалтын сурах бичиг, УБ 2012.